



МОНГОЛ УЛСЫН  
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН  
САЙДЫН ТУШААЛ

2017 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/38

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.3 дахь хэсэгт заасныг үндэслэн ТУШААХ нь:

1."Нэг цэгийн үйлчилгээний төвийн аюулгүй байдалд хяналт тавих журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг Цагдаагийн ерөнхий газрын дарга /тэргүүн комиссар Ө.Энхтөр/-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга /Э.Энхтуяа/, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны дарга /Л.Нямгэрэл/ нарт тус тус даалгасугай.

САЙД



С.БЯМБАЦОГТ

Хууль зүй, дотоод хэргийн сайдын  
2017 оны 02 дугаар сарын 14-ны  
өдрийн 133 дугаар тушаалын  
хавсралт



## НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

### Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмын зорилго нь гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид эмнэлэгт түшиглэсэн нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх үеийн аюулгүй байдалд хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2.Үйлчилгээг үзүүлэхдээ үйлчлүүлэгч болон ажилтнуудын аюулгүй байдлыг тэргүүн зэрэгт тавина.

1.3.Нэг цэгийн үйлчилгээний төв нь MNS ..... Монгол Улсын стандартаар тавигдах шаардлагыг хангасан байна.

1.4.Нэг цэгийн үйлчилгээний төвийн байр нь хүүхэд, эрэгтэй, эмэгтэй хүн, хөгжлийн бэрхшээлтэй, гэр бүлийн гишүүн байрлах тусгай өрөөнүүдтэй байна.

1.5.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 33 дугаар зүйлд заасан үйлчилгээг нэг цэгийн төвөөр үзүүлэх үед тухайн төвийн харьяалах нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагаас хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд учирсан аюулын зэргээс шалтгаалж аюулгүй байдлыг хангаж ажиллана.

### Хоёр. Нэг цэгийн үйлчилгээний төвийн байрны аюулгүй байдлыг хангах

2.1.Нэг цэгийн үйлчилгээний төвийг нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын хөдөлгөөнт болон явган эргүүлийн чиглэлд тусгаж, хяналтад байлгана.

2.2.Төвийн аюулгүй байдлыг хянах зорилгоор дотор болон гадна орчныг хамруулсан телекамерыг 24 цагийн хяналтад байхаар зохион байгуулна.

2.3.Нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага харьяаллын дагуу дуудлагаар тэргүүн ээлжинд шуурхай үйлчилж, шаардлагатай тохиолдолд хойшлуулшгүй ажиллагааг явуулна.

2.4.Нэг цэгийн үйлчилгээний төвийн ажилтан нь дараах үүрэгтэй:

2.4.1.үйлчлүүлж байгаа иргэнд хууль тогтоомж, төвийн дотоод журам мөрдөхийг шаардах;

2.4.2.бусдад хор уршиг учруулж болзошгүй эд зүйл, материал байгаа эсэхийг шалгах;

2.4.3.төвөөр үйлчлүүлэгчдийн бүртгэл, тэмдэглэлийг хөтөлж, эрх бүхий албан тушаалтанд танилцуулах;

2.4.4.үйлчлүүлэгчийн болон мэдээллийн аюулгүй байдлын нууцлалыг хангаж, баримт материалыг баталгаатай, аюулгүй газар хадгалах;

2.4.5.үйлчлүүлэгчид шаардлагатай үйлчилгээний талаарх мэдээллийг өгөх.

## ТАНИЛЦУУЛГА

“Нэг цэгийн үйлчилгээний төвийн аюулгүй байдалд хяналт тавих журам”-ын талаар

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (Шинэчилсэн найруулга) –ийн 36 дугаар зүйлийн 36.4 дэх хэсэгт “Нэг цэгийн үйлчилгээний төвийн аюулгүй байдалд хяналт тавих журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэж заасны дагуу журмын төслийг боловсруулав.

Журмын төслийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль болон Эрүүл мэндийн сайдын 2010 оны 68 дугаар тушаалаар батлагдсан Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртөгсдөд тусламж, үйлчилгээ үзүүлэх эмнэлэгт түшиглэсэн Нэг Цэгийн Үйлчилгээний түр удирдамж, Эрүүл мэнд, Хууль зүй, дотоод хэргийн, Нийгэм хамгаалал, хөдөлмөрийн сайдын хамтарсан 2009 оны 308/189/129 тоот тушаалаар батлагдсан “Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчид үзүүлэх эмнэлэгт түшиглэсэн нэг цэгийн үйлчилгээний журам”, Цагдаагийн байгууллагын гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх журам зэрэг эрх зүйн актад нийцүүлэн боловсрууллаа.

Тус журмаар нэг цэгийн үйлчилгээний төвийн аюулгүй байдалд цагдаагийн байгууллагаас хяналт тавих хүрээ, зохион байгуулалтын арга, талуудын хамтран ажиллах хэлбэрийг зохицуулна.

Энэхүү журам батлагдснаар аюулгүй байдлын хамгаалалтын үйлчилгээнд хамрагдсан хохирогч, түүний гэр бүлийн гишүүдийн аюулгүй байдал бүрэн хамгаалагдах боломж бүрдэнэ.

----oOo----